



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сайншанд сумын Агатова өрхийн эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДГА-2022/74/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Сайншанд 2022 он	Тэргүүлэх аудитор:	Т.Ган-Өлзий
	Утас: 70522734	Цахим хаяг: gan-ulziit@audit.gov.mn
	Аудитын менежер:	У.Оюунтүлхүүр
	Утас: 70523020	Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn
	Багийн ахлагч аудитор:	Ш.Сувдаа
		Цахим хаяг: smaudit97@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,
Утас: (705) 2-27-34

Бээ сайт: dornogovi@audit.gov.mn

2022.02.25 № 16/249

танай _____-ны № _____-т

САЙНШАНД СУМЫН АГАТОВА
ӨРХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ЭРХЛЭГЧ О.УРАНЧИМЭГ ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сайншанд сумын Агатова өрхийн эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сайншанд сумын Агатова өрхийн эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлэн гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Т.ГАН-ӨЛЗИЙ

This PC: D/2022 onii ajil/A4 toot

Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

		/төгрөгөөр/	
	Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	51,017,573.09	288,436,687.24
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	49,117,572.63	48,771,309.27
	Нийт хөрөнгийн дүн	100,135,145.72	337,207,996.51
	Нийт өр төлбөрийн дүн	-	40,910,220.00
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	100,135,145.72	296,297,776.51
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	100,135,145.72	337,207,996.51
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	304,132,398.91	1,137,488,534.02
	Үйл ажиллагааны зардлын дүн	254,198,250.12	941,325,903.23
	Үйл ажиллагааны үр дүн	49,934,148.79	196,162,630.79
	Үйл ажиллагааны бус үр дүн	(25,600.00)	-
	Үйл ажиллагааны нийт үр дүн	49,908,548.79	196,162,630.79
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	50,226,596.93	100,135,145.72
	Тайлант оны үр дүн	49,908,548.79	196,162,630.79
	Эцсийн үлдэгдэл	100,135,145.72	296,297,776.51
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	258,140,768.26	437,551,822.00
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	234,971,966.12	432,877,321.19
	Үйл ажиллагааны ЦМГ	23,168,802.14	4,674,500.81
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	(19,161,700.00)	(1,299,000.00)
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	4,007,102.14	3,375,500.81
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	18,863.41	4,025,965.55
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	4,025,965.55	7,401,466.36
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	220,261,400.00	434,176,321.19
	Урсгал зардал	220,261,400.00	434,176,321.19
	Хөрөнгийн зардал	-	-
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	220,261,400.00	437,551,822.00
	Орон нутгийн төсвөөс санхүүжих	10,220,000.00	10,187,407.00
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	-	63,750,835.00

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Агатова ЗГБХН нь илүү найдвартай, аюулгүй, өндөр соёлтой эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг үзүүлэхийн төлөө өрхийн эрүүл мэндийн төвийн байр суурийг бататгаж, үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамж, итгэл найдвараар дүүрэн, цаг ямагт өөрчлөлт шинэчлэлт дэвшилт хийж, өрхийн эрүүл мэндийн төвийн хөгжлийг тодорхойлсон эмнэлэг болон хөгжих гэсэн зорилго тавин ажиллаж байна.

Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Шалгагдагч байгууллага нь Морьтон-Эрдэнэ ХХК-аас Ковид-19 цар тахалтай холбоотойгоор 5 сая төгрөгийн дэмжлэгийг 2021 оны 4 дүгээр сарын 5-ны өдөр нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан хүлээн авч, Сайхандулаан сумын ЕБ-ын сургуулийн даргын 2021 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн А/22 тушаалаар тус хөрөнгийг зарцуулах тушаал гарган зарцуулсан байна. Тус дэмжлэгийн 3.2 сая төгрөгийг шатахууны зардалд, 0.6 сая төгрөгийг автомашины бэлэн байдлыг хангах зардалд, 0.3 сая төгрөгийг халдваргүйжүүлэлтийн зардалд, 0.2 сая төгрөгийг дархлаажуулалтын зардалд тус тус төлөвлөн зарцуулсан байна.

Дөрөв. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Агатова ЗГБХН нь хуулийн хүрээнд 2021 онд бүтэн жилээр мэдээлэх 9, хагас жилээр мэдээлэх 4, улирал тутамд мэдээлэх 4, сар бүр мэдээлэх 3 төрлийн 36, тухай бүр мэдээлэх 8 төрлийн 96 буюу нийт 149 мэдээллийг хугацаанд нь бүрэн оруулсан байна.

Төсвийн гүйцэтгэлийн мэдээ, санхүүгийн тайлан, аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, худалдан авах ажиллагааны мэдээллийг шилэн дансны цахим системд хуулиар тогтоосон хугацаанд, бүрэн байршуулсан байна.

Аймгийн ЭМГ-т байгууллага, аж ахуй нэгж, иргэдээс хандивласан нэг удаагийн хамгаалах хэрэгсэл болон эм боох материал, эмнэлгийн хэрэгслийг холбогдох дээд байгууллагын тушаал шийдвэрийн дагуу 453.3 сая төгрөгийн хөрөнгийг зохих журмаар данс бүртгэлд тусган зориулалтын дагуу зарцуулсан байна.

Аж ахуй нэгж, иргэдээс хандивласан нэг удаагийн хамгаалах хувцас хэрэгсэл болон ариутгал халдваргүйжүүлэлтийн материалыг хүлээн авч байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлөөр үнэлгээ тогтоон нийт 4.8 сая төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд тусгасан байна.

Бусад хууль тогтоомжийн хэрэгжилтэд тусгайлсан аудит хийгдээгүй болно.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1 зөвлөмж өгсөн бөгөөд Э баримтын бүрдэл хангаж ажиллах зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилласан байна

Тав. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татах асуудал гаргаагүй болно

Зургаа. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 10,050.8 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 9,711.2 мянган төгрөгийн алдааг залруулж, 339.6 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа:

1. Үнэ төлбөргүй хүлээн авсан 8,072.6 мянган төгрөгийн хөрөнгийг ҮХ-ийн тодруулга тайланд буруу ангилж бүртгэсэн нь НББ-ийн тухай хуулийн НББ-ийн зарчмын 5 дугаар зүйлийн 5.1.4-т “Үнэн зөв байх” гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна. Аудитаар алдааг залруулан бүртгэв.

2. Үндсэн хөрөнгийн тодруулга тайланд худалдаж авсан үндсэн хөрөнгийг 1,638.6 мянган төгрөгөөр дутуу тусгасан байсныг аудитаар залруулав.

Зөвлөмж:

1. Нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 339.6 мянган төгрөгийг тооцооны дансаар дамжуулалгүйгээр шууд зардалд бүртгэсэн байна.

Өгсөн зөвлөмж: Ажил гүйлгээг тооцооны дансаар дамжуулж зардалд бүртгэж байх

1. Тээврийн хэрэгслийн оношилгооны төлбөрөөс 0.006 сая төгрөгийн автотээвэр, өөрөө явагч хэрэгслийн хэрэгслийн албан татварыг төлсөн нь Төсвийн тухай хуулийн 16.5.5 дахь заалт мөн 2021 оны Сангийн сайдын 190 дүгээр тушаалыг тус тус зөрчиж, ангилал батламж мэдэгдлийг хангахгүй байна.
2. Шилэн дансанд мэдээлэх шаардлагатай 5.0 сая төгрөгөөс дээш дүн бүхий зарлагын гүйлгээг мэдээлээгүй, хөрөнгө зарцуулах тухай 43 тушаал, шийдвэрээс 14 тушаалыг шилэн дансанд огт байршуулаагүй нь Шилэн дансны тухай хуулийн 6.4.5 дахь заалт, 6.4.8 дахь заалтыг тус тус зөрчиж, нийцтэй бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая.төгрөг/

Д/Д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Агатова ЗГБХН	3	10.1	2	9.7	-	-	-	-	1	0.3